



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2026 оны 02 дугаар сарын 23
№08 (1403)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

28.	Журам батлах тухай	Дугаар 224	539
29.	Жагсаалт шинэчлэн батлах тухай	Дугаар 264	548
30.	Журам батлах тухай	Дугаар 266	553
31.	Үндэсний хорооны дүрэм батлах тухай	Дугаар 270	561



ТЭГЖИЛ		1
ТЭГЖИЛ		2
ТЭГЖИЛ		3
ТЭГЖИЛ		4
ТЭГЖИЛ		5
ТЭГЖИЛ		6
ТЭГЖИЛ		7
ТЭГЖИЛ		8
ТЭГЖИЛ		9
ТЭГЖИЛ		10
ТЭГЖИЛ		11
ТЭГЖИЛ		12
ТЭГЖИЛ		13
ТЭГЖИЛ		14
ТЭГЖИЛ		15
ТЭГЖИЛ		16
ТЭГЖИЛ		17
ТЭГЖИЛ		18
ТЭГЖИЛ		19
ТЭГЖИЛ		20
ТЭГЖИЛ		21
ТЭГЖИЛ		22
ТЭГЖИЛ		23
ТЭГЖИЛ		24
ТЭГЖИЛ		25
ТЭГЖИЛ		26
ТЭГЖИЛ		27
ТЭГЖИЛ		28
ТЭГЖИЛ		29
ТЭГЖИЛ		30
ТЭГЖИЛ		31
ТЭГЖИЛ		32
ТЭГЖИЛ		33
ТЭГЖИЛ		34
ТЭГЖИЛ		35
ТЭГЖИЛ		36
ТЭГЖИЛ		37
ТЭГЖИЛ		38
ТЭГЖИЛ		39
ТЭГЖИЛ		40
ТЭГЖИЛ		41
ТЭГЖИЛ		42
ТЭГЖИЛ		43
ТЭГЖИЛ		44
ТЭГЖИЛ		45
ТЭГЖИЛ		46
ТЭГЖИЛ		47
ТЭГЖИЛ		48
ТЭГЖИЛ		49
ТЭГЖИЛ		50
ТЭГЖИЛ		51
ТЭГЖИЛ		52
ТЭГЖИЛ		53
ТЭГЖИЛ		54
ТЭГЖИЛ		55
ТЭГЖИЛ		56
ТЭГЖИЛ		57
ТЭГЖИЛ		58
ТЭГЖИЛ		59
ТЭГЖИЛ		60
ТЭГЖИЛ		61
ТЭГЖИЛ		62
ТЭГЖИЛ		63
ТЭГЖИЛ		64
ТЭГЖИЛ		65
ТЭГЖИЛ		66
ТЭГЖИЛ		67
ТЭГЖИЛ		68
ТЭГЖИЛ		69
ТЭГЖИЛ		70
ТЭГЖИЛ		71
ТЭГЖИЛ		72
ТЭГЖИЛ		73
ТЭГЖИЛ		74
ТЭГЖИЛ		75
ТЭГЖИЛ		76
ТЭГЖИЛ		77
ТЭГЖИЛ		78
ТЭГЖИЛ		79
ТЭГЖИЛ		80
ТЭГЖИЛ		81
ТЭГЖИЛ		82
ТЭГЖИЛ		83
ТЭГЖИЛ		84
ТЭГЖИЛ		85
ТЭГЖИЛ		86
ТЭГЖИЛ		87
ТЭГЖИЛ		88
ТЭГЖИЛ		89
ТЭГЖИЛ		90
ТЭГЖИЛ		91
ТЭГЖИЛ		92
ТЭГЖИЛ		93
ТЭГЖИЛ		94
ТЭГЖИЛ		95
ТЭГЖИЛ		96
ТЭГЖИЛ		97
ТЭГЖИЛ		98
ТЭГЖИЛ		99
ТЭГЖИЛ		100

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 05 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 224

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Инновацийн тухай хуулийн 6.1.7-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Инновацийн төслийг улсын төсвөөс санхүүжүүлэх журам”-ыг 1 дүгээр хавсралт, “Инновацийн үйл ажиллагаанд оролцогчид грант олгох журам”-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2.Энэ тогтоолын 1-д заасан санхүүжилт болон грант олгоход шаардагдах зардлыг 2025 оны батлагдсан төсөвтөө багтаан, цаашид шаардагдах зардлыг жил бүрийн улсын төсвийн төсөлд тусган санхүүжүүлж байхыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгасугай.

3.Журмын хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүүд үүрэг болгосугай.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 497 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Шинжлэх ухаан, технологийн сангаас тэтгэлэг олгох, сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ын 3.9 заалтын “3.5.6-д заасан грантыг Засгийн газраас баталсан “Инновацийн үйл ажиллагаанд оролцогчид грант олгох журам”-ын дагуу, мөн” гэснийг хасаж, мөн журмын 3.5.6 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

5.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2018 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн 99 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД**

Ц.БААТАРХҮҮ

Засгийн газрын 2025 оны 05 дугаар
сарын 07-ны өдрийн 224 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт

ИННОВАЦЫН ТӨСЛИЙГ УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмаар инновацын төсөл шалгаруулах, санхүүжүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих, үр дүнг тооцох үйл ажиллагааг зохицуулна.

1.2.Инновацын төсөл (цаашид “төсөл” гэх) нь Инновацийн тухай хуулийн 4.1.2-т заасан зарчимд нийцсэн байна.

Хоёр.Төсөлд тавигдах шаардлага

2.1.Төсөл нь Инновацийн тухай хуулийн 14.1-д заасан шаардлагыг хангасан байна.

2.2.Төсөл хэрэгжүүлэгч нь дараах шаардлагыг хангасан байна:

2.2.1.инновацын бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд гаргах боломжит хугацааг хуваарь гарган төлөвлөж ирүүлсэн байх;

2.2.2.төслийг амжилттай хэрэгжүүлэх хүний нөөц, санхүүгийн чадавхтай байх;

2.2.3.хугацаа хэтэрсэн аливаа өр төлбөргүй байх;

2.2.4.энэ журмын 4.2-т зааснаас хэтэрсэн санхүүжилтийг бусад эх үүсвэр (өөрийн хөрөнгө, банк, хөрөнгө оруулалтын сан, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт)-ээс бүрдүүлсэн байх.

2.3.Төслийн санхүүжилтийг доор дурдсан үйл ажиллагаанд зарцуулна:

2.3.1.инновацын бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэхэд шаардагдах үндсэн тоног төхөөрөмж, сэлбэг, багаж хэрэгсэл худалдан авах, тээвэрлэх, суурилуулах;

2.3.2.түүхий эд, материал, урвалж бодис, программ хангамж зэргийг худалдаж авах, тээвэрлэх, суурилуулах.



2.4.Төслийн санхүүжилтийг судалгааны ажил гүйцэтгэх, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулахад зарцуулахгүй.

2.5.Өмнө нь санхүүжилт олгож байсан төсөлд дахин санхүүжилт олгохгүй.

Гурав.Төсөл шалгаруулах

3.1.Өндөр технологи, үндэсний инновацыг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас инновацын төслийн сонгон шалгаруулалтын мэдээллийг тухайн оны II улиралд багтаан олон нийтэд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зарлаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулна.

3.2.Төсөл хэрэгжүүлэгч энэ журмын 3.1-д заасан зарын дагуу төслийн саналыг өндөр технологи, үндэсний инновацыг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.3.Энэ журамд заасан нөхцөл, шаардлагыг хангасан төслийг сонгон шалгаруулалтад оролцуулна.

3.4.Шинжээч нь төсөлд үнэлгээ өгч, дүгнэлт гаргахдаа энэ журам болон өндөр технологи, үндэсний инновацыг хөгжүүлэх асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан “Инновацийн бүтээгдэхүүний талаар дүгнэлт гаргах, мэргэжлийн шинжээчдийн ажиллах журам”-ыг баримтална.

3.5.Сонгон шалгаруулалтад ирүүлсэн төсөлд үнэлгээ өгч, дүгнэлт гаргах мэргэжлийн шинжээчдийг өндөр технологи, үндэсний инновацыг хөгжүүлэх асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр томилно.

3.6.Энэ журмын 3.4-т заасан журмын дагуу шалгарсан инновацын төсөлд улсын төсвөөс санхүүжилт олгох шийдвэрийг өндөр технологи, үндэсний инновацыг хөгжүүлэх асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гаргана.

Дөрөв.Гэрээ байгуулах, санхүүжилт олгох

4.1.Өндөр технологи, үндэсний инновацыг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 3.6-д заасан шийдвэрийг үндэслэн төсөл хэрэгжүүлэгчтэй хуанлийн 30 өдрийн дотор гэрээ байгуулна.

4.2.Нэг төсөлд олгох санхүүжилтийн дээд хэмжээ 60 сая төгрөгөөс хэтрэхгүй, төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах нийт санхүүжилтийн 40 хувиас ихгүй байна.

4.3.Төслийн санхүүжилтийг өндөр технологи, үндэсний инновацыг хөгжүүлэх асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний төсвийн багцаас нэг удаа бүрэн хэмжээгээр олгоно.

Тав.Төслийн хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тооцох

5.1.Төслийн хэрэгжилтэд өндөр технологи, үндэсний инновацыг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина.

5.2.Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн хэрэгжилтийн явц болон санхүүжилтийн тайланг жил бүрийн 02 дугаар сард багтаан өндөр технологи, үндэсний инновацыг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

5.3.Төсөл хэрэгжүүлэгч гэрээний хугацаа дууссанаас хойш 2 сарын дотор гүйцэтгэлийн нэгдсэн тайланг өндөр технологи, үндэсний инновацыг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүлээлгэж өгнө.

5.4.Өндөр технологи, үндэсний инновацыг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын инновацын бодлого зохицуулалтын асуудал хариуцсан нэгж нь газар дээрх хяналтыг хийж, гэрээний биелэлт, үр дүнгийн тайлан гаргана.

5.5.Төслийн үр дүнг дараах үзүүлэлтээр үнэлнэ:

5.5.1.гэрээнд заасан хугацаанд зах зээлд шинээр нэвтрүүлсэн инновацын бүтээгдэхүүн, үйлчилгээг бүртгүүлсэн, бий болгосон, арилжсан, төлбөр, тооцоо гүйцэтгэсэн, хадгалсантай холбоотой үзүүлэлтийн тоо, хэмжээ;

5.5.2.төсөл хэрэгжүүлсэн хугацаанд олсон орлого, гаргасан зардал, түүний хэмнэлт, ашиг, борлуулалт, үйлдвэрлэл, экспортод гарсан бүтээгдэхүүний хэмжээ зэрэг татварын байгууллагад хүргүүлсэн санхүүгийн тайлангийн баталгаажуулсан үзүүлэлт;



5.5.3.зах зээл дэх ижил төстэй бүтээгдэхүүн, үйлчилгээнээс өрсөлдөх чадвараар илүү болохыг нотолсон техник, эдийн засгийн үзүүлэлт;

5.5.4.нэмүү өртөг бий болгосон байдал.

5.6.Төслийн гүйцэтгэлийн явц нь санхүүжүүлэгчээс үл хамааран удааширсан, төслийн үр дүн гэрээнд заасан хэмжээнд хүрээгүй, энэ журмын 2.3-т зааснаас өөр зориулалтаар ашигласан, 5.2-т заасан хугацаанд багтаан тайлан ирүүлээгүй бол өндөр технологи, үндэсний инновацыг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас нэг талын санаачилгаар мэдэгдэл хүргүүлж гэрээг цуцална.

5.7.Энэ журмын 5.6-д заасан нөхцөл үүссэн тохиолдолд санхүүжилт авсан этгээдийн төслийн сонгон шалгаруулалтад оролцох эрхийг 3 жилийн хугацаагаар түдгэлзүүлж, санхүүжүүлсэн хөрөнгийг нөхөн төлүүлэх арга хэмжээг өндөр технологи, үндэсний инновацыг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.

Зургаа.Бусад

6.1.Энэ журмын 5.7-д зааснаас бусад аливаа маргааныг талууд зөвшилцөх замаар шийдвэрлэх бөгөөд тохиролцож чадаагүй тохиолдолд шүүхийн журмаар шийдвэрлүүлнэ.

----oOo----

Засгийн газрын 2025 оны 05 дугаар
сарын 07-ны өдрийн 224 дүгээр
тогтоолын 2 дугаар хавсралт

ИННОВАЦЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧИД ГРАНТ ОЛГОХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмаар инновацын үйл ажиллагаанд оролцогчийг шалгаруулах, оролцогчдод грант олгох, хэрэгжилтэд нь хяналт тавих, үр дүнг тооцохтой холбогдсон харилцааг зохицуулна.

1.2.Энэ журамд заасан инновацын үйл ажиллагаанд оролцогч (цаашид “оролцогч” гэх) гэдэгт инновацын үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүрэг бүхий хүн, хуулийн этгээд хамаарна.

Хоёр.Тавигдах шаардлага

2.1.Оролцогч нь дараах шаардлагыг хангасан байна.

2.1.1.хүн бол 18 насанд хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай, Монгол Улсын иргэн байх;

2.1.2.хуулийн этгээд бол Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 5.1-д заасан нөхцөлийг хангасан байх.

2.2.Оролцогчийн дэвшүүлсэн инновацын шийдэл нь технологийн туршилт, зүгшрүүлэлтийн үйл ажиллагааг хийх дараах шаардлагыг хангасан байна.

2.2.1.инновацыг хэрэглээнд нэвтрүүлж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадвар, бүтээмжийг дээшлүүлэх, нийгмийн үйлчилгээг сайжруулахад чиглэсэн байх;

2.2.2.лабораторийн түвшинд боловсруулсан технологи, бүтээгдэхүүний загварыг үйлдвэрлэлийн нөхцөлд турших, боловсронгуй болгох, технологийн баримтжуулалт хийхэд чиглэсэн байх;

2.2.3.оюуны өмчийн зөрчилгүй байх.

2.3.Өмнө нь грант олгож байсан инновацын шийдэлд грант дахин олгохгүй.



Гурав.Инновацийн шийдлийг сонгон шалгаруулах

3.1.Инновацийн шийдлийг шалгаруулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамжийг жил бүр өндөр технологи, үндэсний инновацыг хөгжүүлэх асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

3.2.Өндөр технологи, үндэсний инновацыг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага оролцогчид грант олгох нөхцөл, шаардлагыг тухайн оны 2 дугаар улиралд багтаан олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлж, нээлттэй сонгон шалгаруулалтыг зохион байгуулна.

3.3.Оролцогч нь энэ журмын 2-т заасан шаардлагыг хангасан байх ба инновацын шийдлийн дэлгэрэнгүй танилцуулга, холбогдох материалыг өндөр технологи, үндэсний инновацыг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

3.4.Өндөр технологи, үндэсний инновацыг хөгжүүлэх асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ журмын 3.1-д заасан Ажлын хэсгийн дүгнэлтэд үндэслэн шалгарсан оролцогчид грант олгох тухай шийдвэрийг гаргана.

Дөрөв.Гэрээ байгуулах, грант олгох

4.1.Өндөр технологи, үндэсний инновацыг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 3.4-т заасан шийдвэрийг үндэслэн шалгарсан оролцогчтой ажлын 30 өдрийн дотор гэрээ байгуулна.

4.2.Шалгарсан оролцогчид 20.0 сая хүртэл төгрөг, эсхүл түүнтэй дүйцэхүйц хэмжээтэй үнийн дүн бүхий мөнгөн бус хэлбэрээр грантыг олгоно.

4.3.Грантыг өндөр технологи, үндэсний инновацыг хөгжүүлэх асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний төсвийн багцаас нэг удаа бүрэн хэмжээгээр олгоно.

Тав.Төслийн хэрэгжилтэд хяналт тавих

5.1.Энэ журмын 4.1-д заасан гэрээний хэрэгжилтэд өндөр технологи, үндэсний инновацыг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина.

5.2.Энэ журмын 4.1-д заасан хүн, хуулийн этгээд нь гэрээний хэрэгжилтийн явц болон санхүүжилтийн тайланг жил бүрийн 2 дугаар сард багтаан өндөр технологи, үндэсний инновацыг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

5.3.Энэ журмын 4.1-д заасан хүн, хуулийн этгээд нь гэрээний хугацаа дууссанаас хойш 2 сарын дотор гүйцэтгэлийн нэгдсэн тайланг өндөр технологи, үндэсний инновацыг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүлээлгэж өгнө.

5.4.Өндөр технологи, үндэсний инновацыг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын инновацын бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан нэгж нь урьдчилан тохирсон нөхцөл, болзлын биелэлтийг үндэслэн гэрээг дүгнэнэ.

5.5.Гүйцэтгэлийн явц нь өндөр технологи, үндэсний инновацыг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас үл хамааран урьдчилан тохирсон нөхцөл, болзлыг биелүүлээгүй, энэ журмын 5.2-т заасан хугацаанд багтаан тайлан ирүүлээгүй бол нэг талын санаачилгаар гэрээг цуцална.

5.6.Энэ журмын 4.1-д заасан хүн, хуулийн этгээд нь гэрээнд заасан урьдчилан тохирсон нөхцөл, болзлыг биелүүлээгүй бол өндөр технологи, үндэсний инновацыг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тухайн инновацын шийдлийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх давуу эрхтэй байна.

5.7.Энэ журмын 5.5-д заасан нөхцөл үүссэн тохиолдолд тухайн оролцогчийг грант олгох сонгон шалгаруулалтад оролцох эрхийг 3 жилийн хугацаагаар түдгэлзүүлнэ.

Зургаа.Бусад

6.1.Аливаа маргааныг талууд зөвшилцөх замаар шийдвэрлэх бөгөөд тохиролцож чадаагүй тохиолдолд шүүхийн журмаар шийдвэрлүүлнэ.

----o0o----



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 05 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 264

Улаанбаатар
хот

Жагсаалт шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 5.1.5, 5.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын нутаг дэвсгэрт эргэлтийг зөвшөөрөх, олон улсад бүртгэлтэй тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон тэдгээрийн үндсэн түүхий эдийн жагсаалт”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваанд үүрэг болгосугай.

3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан “Жагсаалт шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 74 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС
БАЯЛГИЙН САЙД**

Ц.ТУВААН

[illegible]



Засгийн газрын 2025 оны 05 дугаар
сарын 28-ны өдрийн 264 дүгээр
тогтоолын хавсралт

**МОНГОЛ УЛСЫН НУТАГ ДЭВСГЭРТ ЭРГЭЛТИЙГ ЗӨВШӨӨРӨХ,
ОЛОН УЛСАД БҮРТГЭЛТЭЙ ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС,
ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЭЛ БОЛОН ТЭДГЭЭРИЙН
ҮНДСЭН ТҮҮХИЙ ЭДИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон тэдгээрийн үндсэн түүхий эдийн төрөл	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон тэдгээрийн үндсэн түүхий эдийн төрлийн хэлбэрүүд	БТКУС код
А	Б	В	Г
Нэг.Тэсэлгээний хэрэгсэл			
1.	Цахилгаан тэслүүр	агшны	3603
		удаашруулалттай	
		хамгаалалттай	
		газрын тос, хийн цооногийн	
2.	Цахилгаан бус тэслүүр	цахилгаан бус тэслүүрийн систем угсрах бэлдэц	3603
3.	Цахилгаан бус тэслүүрийн систем	цооног, шпурын	3603
		Гадаргуугийн холбогч блоктой	
		цооногийн болон гадаргуугийн холбогч блоктой хосолсон	
4.	Цочир дамжуулах шижмийн гадаргуугийн удаашруулагч систем	цочир дамжуулах шижмээр холбох	3603
		цохилтын долгион дамжуулах гуурстай холбогч блоктой	
5.	Цахим тэслүүр	утаастай	3603
		утасгүй	

6.	Цохилтын долгион дамжуулах гуурс	цахилгаан бус тэслүүрийн систем угсрах бэлдэц	3603
		тэсэлгээний холболтын шугамын, тэслүүргүй	
		тэсэлгээний холболтын шугамын, тэслүүртэй	
Хоёр.Тэсрэх бодис			
7.	Цэнэг өдөөх тэсрэх бодисын хэрэгсэл бэлтгэх өндөр хүчин чадалтай тэсрэх бодис	RDX	3602
		TNT	3602
		PETN	3602
		PETN, TNT холимог	3602
8.	Өдөөгч тэсрэх бодис	цооног, шпурын	3602
		чиглэсэн үйлчлэлтэй гадаргуугийн	
9.	Перфорацийн цэнэг	газрын тос, хийн цооногийн	3602
10.	Пресплитийн цэнэг	газрын тос, хийн цооногийн	3602
11.	Аммонит тэсрэх бодис	боодолтой, хамгаалалттай	3602
12.	Динамит тэсрэх бодис	бортоготой, чичирхийллийн	3602
13.	Гранулит тэсрэх бодис	мөхлөгтэй, задгай	3602
14.	Анфо тэсрэх бодис	энгийн найрлагатай, савлагаатай	3602
		нэмэлт хольцтой, савлагаатай	
		энгийн найрлагатай, задгай	
		хүнд анфо савлагаатай	
15.	Эмульсийн тэсрэх бодис	савлагаатай, тэслүүрт мэдрэмтгий	3602
		Савлагаатай, тэслүүрт мэдрэмтгий бус	
		задгай	
		анфогийн хольцтой задгай	



16.	Цочир дамжуулах шижим	гадаргуугийн холболтын бага хүчин чадлын	3602
		өндөр хүчин чадлын	
		газрын тос, хийн цооногийн	
Гурав.Үндсэн түүхий эд			
17.	Аммиакийн шүү	Аммиакийн шүү цэвэр	3102.30
		Аммиакийн шүү сүвэрхэг	3102-30
18.	Аммиакийн шүүний эмульс	Задгай, мэдрэгжүүлээгүй	дотоодод зөвшөөрөгдөх

----oOo----

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 05 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 266

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 57.2.3, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 287.8.4, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9.4-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ нь:**

1.“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид мэргэшлийн зэрэг, зэргийн нэмэгдэл олгох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид мэргэшлийн зэрэг олгох шалгуур үзүүлэлтийг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар (Б.Нандинболор)-т үүрэг болгосугай.

3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгоход шаардагдах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Сангийн сайд Б.Жавхлан нарт тус тус үүрэг болгосугай.

4.Энэ тогтоолыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД**

Л.ЭНХ-АМГАЛАН

Засгийн газрын 2025 оны 05 дугаар
сарын 28-ны өдрийн 266 дугаар
тогтоолын хавсралт

**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН
АЛБА ХААГЧИД МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ,
ЗЭРГИЙН НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч (цаашид “офицер, ахлагчид” гэх)-д мэргэшлийн зэрэг олгох, бататгах, ахиулах, бууруулах, хүчингүй болгох болон мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Офицер, ахлагчийн ерөнхий мэдлэг болон эзэмшсэн мэдлэг, ур чадвар, мэргэшлийн түвшнийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын тушаалаар тогтоосон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, мэргэшлийн зэргийг олгоно.

1.3.Мэргэшлийн зэрэг нь I, II, III гэсэн шатлалтай байх бөгөөд мэргэшлийн зэрэг нь дараах хугацаанд хүчинтэй байна.

1.3.1.мэргэшлийн I зэрэг нь 3 жил;

1.3.2.мэргэшлийн II зэрэг нь 3 жил;

1.3.3.мэргэшлийн III зэрэг нь 2 жил.

1.4.Мэргэшлийн зэргийн нэмэгдлийг урамшуулал хэлбэрээр олгохыг хориглоно.

Хоёр.Мэргэшлийн зэргийн шалгалтын комиссын үүрэг

2.1.Офицер, ахлагчид мэргэшлийн зэрэг олгох, бататгах, ахиулах, бууруулах шалгалтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын тушаалаар томилсон Мэргэшлийн зэргийн шалгалтын комисс (цаашид “комисс” гэх) зохион байгуулна.

2.2.Комисс шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага болон түүний харьяа албаны зохион байгуулалтын нэгжийн 7-оос цөөнгүй, сондгой тоотой алба хаагчийн төлөөллөөс бүрдэнэ. Комиссын даргыг гишүүдийн дотроос олонхын саналаар томилно.



2.3.Комиссын дарга нь мэргэшлийн зэрэг олгох комиссын үйл ажиллагааг удирдах, холбогдох баримт бичгийг хянан, шалгах ажлыг зохион байгуулна.

2.4.Комисс нь мэргэшлийн зэрэг олгох, бататгах, ахиулах шалгалтыг жил бүрийн хоёрдугаар улиралд багтаан нэг удаа зохион байгуулна. Мэргэшлийн зэргийн шалгалтыг тухайн жилд нөхөж зохион байгуулахгүй.

2.5.Комисс нь дараах үүрэгтэй:

2.5.1.мэргэшлийн зэрэг эзэмшихтэй холбоотой асуудлаар офицер, ахлагчид мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

2.5.2.мэргэшлийн зэргийн шалгалт явуулах хугацаа, байршлыг тогтоон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргад танилцуулан шийдвэрлүүлэх;

2.5.3.шалгалтын асуулт, дасгал, нормативын хувилбарыг боловсруулан хянаж, баталгаажуулан, нууцлалыг хадгалах;

2.5.4.шалгалтын дүнг нэгтгэн мэргэшлийн зэргийг олгох, бататгах, ахиулах, бууруулах, хүчингүй болгох саналыг боловсруулан баталгаажуулж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргад уламжлан шийдвэрлүүлэх;

2.5.5.мэргэшлийн зэрэг олгох, бататгах, ахиулах, бууруулах, хүчингүй болгохтой холбоотой маргааныг хянаж шийдвэрлэх;

2.5.6.шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд мэргэшлийн зэрэгтэй офицер, ахлагчийн судалгааг хөтөлж, мэргэшлийн зэргийн нэмэгдлийн тооцоог санхүүгийн нэгжтэй хамтран гаргаж, жил бүр тайлагнах.

2.6.Мэргэшлийн зэргийн ерөнхий мэдлэгийн онолын шалгалтыг офицер болон ахлагчийн төрлөөр ялгамжтай тогтооно.

Гурав.Мэргэшлийн зэрэг олгох, бататгах, ахиулах, бууруулах, хүчингүй болгох

3.1.Энэ журмын 6.1.1-д заасан шаардлага хангасан офицер, ахлагч мэргэшлийн зэргийн шалгалтад хамрагдах хүсэлтээ харьяа байгууллагын удирдах албан тушаалтанд бичгээр гаргана.

3.2.Удирдах албан тушаалтан энэ журмын 6.1-д заасан нийтлэг шаардлагыг хангаж байгаа офицер, ахлагчийн нэрсийг дараах баримт бичгийн хамт жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан комисст хүргүүлнэ.

3.2.1.тухайн офицер, ахлагчийн бичгээр гаргасан хүсэлт;

3.2.2.энэ журмын 6.1-д заасан шаардлага хангасныг гэрчлэх баримт.

3.3.Мэргэшлийн зэрэгтэй офицер, ахлагч нь энэ журмын 1.3-т заасан хугацаанд мэргэшлийн зэргээ бататгах, ахиулах шалгалтад хамрагдаж болно.

3.4.Мэргэшлийн зэрэг бататгах, ахиулах шалгалтад доор дурдсан хүндэтгэн үзэх шалтгаанаар хамрагдаагүй офицер, ахлагчийн мэргэшлийн зэргийг дараагийн шалгалт хүртэлх хугацаанд тухайн мэргэшлийн зэргийг хүчинтэйд тооцож, нэмэгдлийг үргэлжлүүлэн олгоно:

3.4.1.офицер, ахлагчийн гэр бүл болон төрсөн эцэг, эх, ах, эгч, дүү нас барсан;

3.4.2.албан томилолттой (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, тэргүүн дэд, дэд даргын тушаал, удирдамжтай).

3.5.Энэ журмын 3.4-т заасан шалтгаанаар мэргэшлийн зэрэг бататгах, ахиулах шалгалтад хамрагдаагүй офицер, ахлагч холбогдох нотлох баримтыг шалгалт зохион байгуулагдсанаас хойш ажлын 3 өдрийн дотор комисст хүргүүлнэ.

3.6.Энэ журмын 6.1-д заасан нийтлэг шаардлагыг хангаж, шалгалтад тэнцсэн офицер, ахлагчид мэргэшлийн зэрэг олгоно.

3.7.Мэргэшлийн зэрэгтэй офицер, ахлагч мэргэшлийн зэргийн шалгалтад тэнцсэн тохиолдолд түүний мэргэшлийн зэргийг бататгана.

3.8.Мэргэшлийн зэрэгтэй офицер, ахлагч нь энэ журмын 6.1.1 дэх заалтад заасан хугацааны шаардлагыг хангаж, зэрэг ахиулах шалгалтад хамрагдаж тэнцсэн тохиолдолд мэргэшлийн зэрэг ахиулан олгоно.

3.9.Мэргэшлийн зэрэг ахиулах, бататгах шалгалтад тэнцээгүй боловч доод шатлалын зэргийн шалгалтын үнэлгээг хангасан тохиолдолд мэргэшлийн зэргийг бууруулна.



3.10.Офицер, ахлагчийн мэргэшлийн зэргийг дараах тохиолдолд хүчингүй болгоно:

3.10.1.мэргэшлийн зэрэг эзэмших хугацаа дуусгавар болсон;

3.10.2.мэргэшлийн зэрэг ахиулах, бататгах шалгалтад хамрагдаж, энэ журмын 6.2-т заасан шалгалтад 60-аас бага оноо авсан;

3.10.3.энэ журмын 3.4-т зааснаас бусад шалтгааны улмаас шалгалтад хамрагдаагүй;

3.10.4.энэ журмын 3.4-т заасан хүндэтгэн үзэх шалтгаанаар зэрэг бататгах, ахиулах шалгалтад хамрагдаагүй офицер, ахлагч журмын 3.5-д заасан баримтыг тогтоосон хугацаанд комисст ирүүлээгүй.

Дөрөв.Мэргэшлийн зэргийн үнэмлэх, тэмдэг олгох

4.1.Энэ журмын 6.2 дахь заалтад тусгасан шалгалт тус бүрд мэргэшлийн III зэрэг горилоч 60-69 оноо, мэргэшлийн II зэрэг горилоч 70-79 оноо, мэргэшлийн I зэрэг горилоч 80 буюу түүнээс дээш оноо авч үнэлэгдсэн бол мэргэшлийн зэргийн үнэмлэх, тэмдэг олгоно.

4.2.Мэргэшлийн зэргийн энгэрийн тэмдгийг албаны болон хээрийн кителийн энгэрийн зүүн халаасыг голлуулан зүүж хэрэглэнэ.

4.3.Мэргэшлийн зэрэг олгогдсон, хүчингүй болсон офицер, ахлагчийн хувийн хэрэгт баяжилт хийнэ.

Тав.Мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох

5.1.Мэргэшлийн зэргийн шалгалтад тэнцсэн офицер, ахлагчид зэргийн нэмэгдлийг албан тушаалын сарын үндсэн цалингаас доор дурдсан хувиар тооцож, сар бүр олгоно:

5.1.1.мэргэшлийн III зэрэг 10 хувь;

5.1.2.мэргэшлийн II зэрэг 15 хувь;

5.1.3.мэргэшлийн I зэрэг 20 хувь.

5.2.Мэргэшлийн зэрэг нь хүчингүй болсон офицер, ахлагчийн мэргэшлийн зэргийн нэмэгдлийг шийдвэр гарсан хугацаанаас эхэлж олгохгүй.

**Зургаа.Мэргэшлийн зэрэг олгоход тавигдах
нийтлэг шаардлага, шалгалт**

6.1.Мэргэшлийн зэргийн шалгалтад дараах нийтлэг шаардлага хангасан офицер, ахлагчийг хамруулна:

6.1.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад 12-36 сар хүртэл ажилласан офицер, ахлагч III зэргийн, 37-72 сар хүртэл ажилласан офицер, ахлагч II зэргийн, 73-аас дээш сар ажилласан офицер, ахлагч I зэргийн шалгалтад тус тус хамрагдах;

6.1.2.сүүлийн 1 жилийн хугацаанд ёс зүйн зөрчил гаргаагүй бөгөөд сахилгын шийтгэл хүлээж байгаагүй;

6.1.3.эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж тэнцсэн дүгнэлт.

6.2.Мэргэшлийн зэргийг энэ журмын 1.2-т тогтоосон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх бөгөөд мэргэшлийн I, II, III зэргийн шалгалт нь офицер, ахлагчийн мэргэшлийн түвшнийг тодорхойлох ерөнхий мэдлэг, галын бэлтгэл болон химийн норматив, бие бялдрын бэлтгэлжилтийн түвшин тогтоох дараах шалгалтаас бүрдэнэ:

6.2.1.ерөнхий мэдлэгийг салбарын хууль, эрх зүй, гадаад хэл, сэтгэн бодох чадвар, компьютерын өргөн хэрэглээний программ ашиглах чадварын сорилоор;

6.2.2.галын бэлтгэл болон химийн норматив гүйцэтгэх ур чадвараар;

6.2.3.бие бялдрын бэлтгэлжилтийн түвшний шалгалтад биеийн зохистой харьцааг хангасан офицер, ахлагч хурд, хүч, авхаалж самбаа, тэсвэрийн сорилоор.

6.3.Ерөнхий мэдлэгийг сорилоор, галын бэлтгэл, химийн болон бие бялдрын бэлтгэлжилтийг нормативын дагуу үнэлнэ.

6.4.Ерөнхий мэдлэгийн шалгалтад тэнцсэн офицер, ахлагч галын бэлтгэл болон химийн норматив, бие бялдрын бэлтгэлжилтийн шалгалтад хамрагдана.



Долоо.Бусад

7.1.Офицер, ахлагч жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй байх хугацаанд мэргэшлийн зэргийн хүчинтэй хугацааг түдгэлзүүлж, нэмэгдлийг олгохгүй бөгөөд хууль тогтоомжийн дагуу ажилдаа эргэн орсон хугацаанаас эхлэн тухайн мэргэшлийн зэргийн хүчинтэй хугацааг үргэлжлүүлэн тооцно.

7.2.Байгалийн гамшиг, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдал үүссэн үед Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын тушаалаар зэргийн шалгалтын хугацааг хойшлуулж, хүчинтэй зэргийн нэмэгдлийг тухайн хугацаанд үргэлжлүүлэн олгоно.

----oOo----

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 05 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 270

Улаанбаатар
хот

Үндэсний хорооны дүрэм батлах тухай

Биеийн тамир, спортын тухай хуулийн 9.2-т заасныг үндэслэн
Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Олимп, паралимпын наадамд оролцох үндэсний шигшээ
багийн бэлтгэл ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах Үндэсний
хороо”-ны дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэ тогтоолын 1-д заасан Үндэсний хорооны үйл ажиллагаанд
шаардагдах зардлыг тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан
санхүүжүүлж байхыг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд
Ч.Номинд үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Соёл,
спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номинд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**СОЁЛ, СПОРТ,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,
ЗАЛУУЧУУДЫН САЙД**

Ч.НОМИН

Засгийн газрын 2025 оны 05 дугаар
сарын 28-ны өдрийн 270 дугаар
тогтоолын хавсралт

**ОЛИМП, ПАРАЛИМПЫН НААДАМД ОРОЛЦОХ ҮНДЭСНИЙ ШИГШЭЭ
БАГИЙН БЭЛТГЭЛ АЖЛЫГ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТААР
ХАНГАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДҮРЭМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ дүрмээр Монгол Улсын үндэсний шигшээ багийг олимп, паралимпын наадамд оролцуулах бэлтгэл ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах, дэмжлэг үзүүлэх, хяналт тавих үүрэг бүхий Үндэсний хороо (цаашид “Хороо” гэх)-ны чиг үүрэг, үйл ажиллагаатай холбогдох харилцааг зохицуулна.

1.2.Хороо үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Биеийн тамир, спортын тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

1.3.Хороо нь тогтоосон журмын хүрээнд албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ.

Хоёр.Хорооны удирдлага, зохион байгуулалт

2.1.Хороог биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тэргүүлнэ.

2.2.Хорооны дэд дарга нь Монголын үндэсний олимпын хорооны ерөнхийлөгч байна.

2.3.Хорооны нарийн бичгийн дарга нь биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нэгжийн болон Биеийн тамир, спортын улсын хорооны Үндэсний шигшээ багийн холбогдох нэгжийн дарга байна.

2.4.Хорооны бүрэлдэхүүнд биеийн тамир, спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, спортын зүтгэлтэн, тамирчдын төлөөллийг оролцуулж болно.

2.5.Хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд хагас жил тутам нэгээс цөөнгүй удаа хуралдана. Шаардлагатай



бол Хорооны ээлжит бус хуралдааныг Хорооны дарга зарлан хуралдуулж болно. Хуралдааны товыг Хорооны дарга тогтооно.

2.6.Хуралдааныг Хорооны дарга, түүний эзгүйд дэд дарга удирдана. Хуралдааныг дэд дарга удирдсан тохиолдолд хуралдаанаас гаргасан шийдвэрийг Хорооны даргад танилцуулна.

2.7.Хорооны хуралдааныг нийт гишүүдийн олонх оролцсоноор хүчинтэйд тооцох бөгөөд хэлэлцсэн асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ. Санал тэнцсэн тохиолдолд хуралдаан даргалагчийн саналаар шийдвэрлэнэ.

2.8.Хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан зөвлөх мэргэжилтэн, шинжээч, төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, олон улсын байгууллагын төлөөллийг саналын эрхгүй оролцуулж болно.

2.9.Хорооны хуралдаанаар шийдвэрлэсэн асуудлаар тогтоол гаргаж, Хорооны дарга гарын үсэг зурна. Хорооны хуралдаанаар хэлэлцсэн асуудлаар тухай бүр тэмдэглэл хөтлөн Хорооны дарга, нарийн бичгийн дарга нар гарын үсэг зурна.

2.10.Хорооны хуралдааныг цахим хэлбэрээр зохион байгуулж болох бөгөөд энэ тохиолдолд хуралдаанаар хэлэлцэх асуудал, шийдвэрийн төсөл, бусад баримт, материалыг гишүүдэд урьдчилан хүргүүлнэ. Цахим хуралдааны шийдвэрийг гишүүдийн гарын үсгээр нөхөн баталгаажуулна.

2.11.Үндэсний шигшээ багийг олимп, паралимпын наадамд амжилттай оролцуулахад бэлтгэх ажлыг удирдах, зохион байгуулалтаар хангах, дэмжлэг үзүүлэхэд Хорооны үйл ажиллагаанд шаардагдах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

2.12.Хороо нь олимп, паралимпын зуны болон өвлийн наадмын бэлтгэл ажлын үйл ажиллагааны тайланг тухайн олимпын наадам өндөрлөснөөс хойш гурван сарын дотор Хорооны хуралдаанаар хэлэлцүүлж, Засгийн газрын хуралдаан болон олон нийтэд танилцуулна.

2.13.Хорооны хуралдаанаар хэлэлцсэн асуудалтай холбоотой аливаа мэдээллийг хуралдааны шийдвэр баталгаажих хүртэл бусдад тараахыг хориглоно.

Гурав.Хороо болон Хорооны гишүүдийн чиг үүрэг

3.1.Хороо дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1.тухайн олимп, паралимпын зун, өвлийн наадамд бэлтгэх ажлын үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн батлах;

3.1.2.бэлтгэл ажлын хүрээнд холбогдох төрийн байгууллагуудын салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

3.1.3.олимп, паралимпын зун, өвлийн наадамд бэлтгэх чиглэлээр төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллага, төрийн бус байгууллага, албан тушаалтанд үүрэг, даалгавар өгөх, хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжилтийн явцын мэдээлэл, тайлан гаргуулж авах, шаардлагатай арга хэмжээг авах талаар шийдвэр гаргах, үр дүнг хэлэлцэх;

3.1.4.олимп, паралимпын наадамд бэлтгэх ажлын явцтай танилцан тайлан, мэдээллийг хэлэлцэх;

3.1.5.олимп, паралимпын наадамд оролцогчдоос нийгэмд эерэг хандлага түгээх, үлгэр дуурайлал болох, зохих ёс зүйн хэм хэмжээг сахих шаардлагыг тогтоох;

3.1.6.олимп, паралимпын наадамд бэлтгэх асуудлаар төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс гаргасан санал, санаачилгыг дэмжиж, арга хэмжээ авах, хамтран ажиллах;

3.1.7.үндэсний шигшээ багийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл, сонсголыг хэлэлцэн зөвлөмж гаргах;

3.1.8.хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн болон бусад төрлийн сүлжээ ашиглан Хороо, олимп, паралимпын шигшээ баг, ивээн тэтгэгч, зохион байгуулагчдын үйл ажиллагааны талаар нийтэд тогтмол мэдээлэх үйл ажиллагаа явуулах;

3.1.9.Хорооны Ажлын албаны үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах, хяналт тавих;

3.1.10.хууль тогтоомжид заасан бусад.

3.2.Хорооны гишүүн дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:



3.2.1.Хорооны хуралдаанд холбогдох асуудлаар санал оруулж, хэлэлцүүлэх;

3.2.2.Хорооны шийдвэрийн хэрэгжилтийн явц, үр дүнтэй танилцах, хариуцсан чиглэлийн дагуу зөвлөгөө өгөх, санал, хүсэлтийг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих;

3.2.3.Хорооны хуралдаанаас гарсан шийдвэр, үүрэг, даалгаврын биелэлтийг хангах, тайлагнах;

3.2.4.хариуцсан салбар, чиглэлийн хүрээнд мэдээ, тайлан, судалгаа, статистик тоо баримтыг Хороонд гаргаж өгөх, тайлагнах;

3.3.5.Хороо болон Хорооны Ажлын албаны үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлантай танилцах, хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээлэл авах.

Дөрөв.Хорооны Ажлын алба

4.1.Хорооны өдөр тутмын үйл ажиллагааг Ажлын алба гүйцэтгэнэ.

4.2.Ажлын албаны чиг үүргийг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын биеийн тамир, спортын бодлогын асуудал хариуцсан нэгж гүйцэтгэнэ.

4.3.Ажлын алба дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

4.3.1.Хорооны үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан батлуулах, төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тайлагнах;

4.3.2.Хорооны гишүүдийг шаардлагатай мэдээллээр хангах, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

4.3.3.Хорооноос гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг уялдуулан зохион байгуулах;

4.3.4.Хорооны үйл ажиллагаанд шаардагдах мэдээлэл, судалгаа, статистик тоо баримт, лавлагааг холбогдох байгууллагуудаас гаргуулах, бэлтгэх, мэдээллийн сан бүрдүүлэх, Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах тухай хуулийн 8.1-д заасны дагуу нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах;

4.3.5.Хорооны хуралдааныг зохион байгуулах бэлтгэл ажил хангах, Хорооны шийдвэрийг албажуулах арга хэмжээ авч, Хорооны гишүүд, холбогдох бусад байгууллагад хүргүүлэх;

4.3.6.Хорооны албан хэрэг хөтлөлтийг холбогдох журмын дагуу гүйцэтгэх, хадгалалт, хамгаалалтыг хариуцах.

----o0o----



Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 2

Индекс: 200003